

**“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН  
Д.ТҮВШИНТАМИРЫН 2022 ОНЫ 02 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 07 дугаар  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 02 дугаар улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд нийт 5 удаа хуульд заасны дагуу танхимаар болон цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах тогтоол, шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнд:

1. 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:
  - 1) Хувьцаа эзэмшигч “Улаанбаатар импекс” ХХК-аас ирүүлсэн хувьцаа худалдан авах саналыг хэлэлцэж, 682ш энгийн хувьцааг худалдан авахаар шийдвэрлэсэн.
  - 2) Хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-иас хувьцаа худалдан авах саналыг ирүүлээгүй тул татгалзсанд тооцож шийдвэрлэсэн.
  - 3) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдааны товыг 2022 оны 05 дугаар сарын 05-нд зарлаж, энэхүү хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэв. Үүнд:
    - Хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн татгалзсан хувьцааг бусад хувьцаа эзэмшигчид санал болгох;
    - “МВАРМ” ХХК-ийн хувьцааны тухай.
  - 4) Корреспондент банктай хамтран ажиллах, Гүйцэтгэх удирдлагад эрх олгох тухай асуудлуудыг тус тус хэлэлцэв.
2. 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь 100 хувийн ирцтэйгээр дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:
  - 1) Банкны үйл ажиллагааны системийг сайжруулах, НЕС системрүү шилжүүлэх, дэд системүүдийг шинээр зохион байгуулахтай холбоотой дэд бүтэц, техник, тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой асуудлыг хэлэлцэж, “Ай Ти Зон” ХХК болон “Саммит” ХХК зэрэг 2 компаниас аль нэгийг сонгох тухай санал солилцож, эдгээр тоног төхөөрөмжүүд нь Dell брэндийн эсхүл түүнтэй дүйцэх хэмжээний үзүүлэлттэй байх шаардлагатай бөгөөд 7 хоногийн дотор худалдан авах, мөн Cloud түрээслэх асуудал дээр дахин судалгаа хийх тухай хэлэлцэв.
  - 2) Тусгай активын хэлтсийн шинжээч н.Баянмөнхийн танилцуулснаар дараах асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэв.
    - ӨБХ - Д.Баттулга - ЧД, 16-р хороо, Согоотыг 56-р гудамж, 670 тоот хаягт байршилтай 700м.кв газар 390 м.кв талбайтай хувийн сууцыг 52,5 сая төгрөгөөр борлуулах санал оруулж ирснийг дэмжсэн.
    - ӨБХ - Н.Баяржаргал - СБД 15-р хороо Дамбадаржаа 83-р гудамж, 219 тоот хувийн сууцыг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэгдсэн дүн болох 34,1 сая төгрөгөөр борлуулж, 10%-ийн хямдрал үзүүлэх тухай санал оруулж ирснийг 34,1 сая төгрөгөөр борлуулахыг зөвшөөрч, 10% хямдруулах саналыг татгалзан шийдвэрлэв.

- ӨБХ - 3.Төмөрчөдөр - ЧД, 12-р хороо Булгийн 6-р гудамж, 393 тоот хувийн сууцны зориулалттай өмчлөх эрхтэй 520м.кв газрын хөндлөнгийн үнэлгээ 348,2 сая төгрөг бөгөөд анх зээл авсан үнийн дүн 250 сая төгрөг байдаг. Иймд хөндлөнгийн үнэлгээний 348,2 сая төгрөгөөр борлуулах, 10%-ийн хямдруулах саналыг ТУЗ дэмжин шийдвэрлэв.
  - ӨБХ - Г.Хос-Эрдэнэ - БГД, 6-р хороо, 10-р хороолол, ХД-57-р байр, 3 давхрын орон сууц анх зээл авсан үнийн дүн 30 сая төгрөг, хөндлөнгийн үнэлгээгээр 35,2 сая төгрөгөөс 10% хямдруулаад худалдан борлуулах саналыг ТУЗ дэмжин шийдвэрлэв.
  - ӨБХ БЗД 17-р хороо, Шархадны гудамж, 59б байрны 1 болон 2 давхарт байрлах 20ш 340м.кв талбайтай үйлчилгээний барилга 98%-ийн гүйцэтгэлтэй талбайг павильоныг 1м.кв нь 1 сая 650 мянгаас 10% хямдруулан нийт 558 саяар худалдан борлуулах саналыг оруулж, ТУЗ дэмжин шийдвэрлэв.
  - ӨБХ - "Чойжин Сүйтс" - СБД, 1-р хороо, Соёл амралтын гудамж, 22-р барилга 205 тоотын 114м.кв орон сууцыг 1 м.кв нь 9,9 сая төгрөгөөр /НӨАТ тооцсон/ худалдан борлуулах санал өгөв.
  - ӨБХ - С.Тэсийнчулуун - Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 3-р багийн Ширээ нуур хороолол, 24-01А тоотын хөндлөнгийн үнэлгээ 11,7 сая төгрөг ба худалдан борлуулах үнийг судлахаар шийдвэрлэв.
  - ӨБХ - С.Цэрэнханд - Дархан-Уул аймаг, Дархан сум, 15-р баг, Манчирт 10 хэсэг, 4-р гудамж, 112м.кв хувийн сууц ба анх зээл авсан үнийн дүн 12 сая төгрөг бөгөөд хөндлөнгийн үнэлгээгээр 7,7 сая төгрөгөөр үнэлэгдсэн. Уг үнэлгээний 7,7 сая төгрөгөөр худалдах санал оруулав.
  - Налайх дүүрэг, 3-р хороо, Дэнжийн 19 гудамж, 22 тоот орон сууцны зориулалттай 117м.кв орон сууц, газрын шийдвэр хүчингүй болсон. Анх 2003 онд 31,000 доллар зээл олгосон.
3. 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:
- 1) "Улаанбаатар импекс" ХХК-аас ирүүлсэн хувьцаа худалдан авах саналыг хүлээн авах, гэрээнд гарын үсэг зурах эрх олгох тухай асуудлыг хэлэлцэв;
  - 2) Ариг банкны орон тооны шилжүүлэгт, албан тушаалын нийт 208 орон тоотой, 70 хувь нь төв оффист, 30 хувь нь салбар дээр ажиллаж байгаа. Бизнес төлөвлөгөөгөөр баталсан орон тоо, зардлын дээд хязгаарт багтаан өөрчлөх эрхийг Гүйцэтгэх захиралд өгөх;
  - 3) Бизнес банкны харьяа иргэдийн банкны хэлтэс "40 мянгат төв"-ийн түрээсийн гэрээний асуудлыг хэлэлцсэн бөгөөд 2016 онд ТУЗ-ийн тогтоол нөхөж гаргаад 2017 онд шилжүүлсэн асуудлыг ахин нягталж ТУЗ-д танилцуулахаар шийдвэрлэв.
4. 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:
- 1) Ариг банкны зээлийн бодлого батлахтай холбоотойгоор дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:
    - Зээлийн бүтээгдэхүүн, нөхцөл хязгаарлалтууд дээр өөрчлөлт орсон ба холбогдох саналыг оруулж, батлахаар шийдвэрлэв.
    - Гүйцэтгэх захирлын зээлийн хүсэлт шийдвэрлэх эрх хэмжээг тогтоох тухай Монгол банкнаас баталсан журмын дагуу Гүйцэтгэх захирал нь банкны

өөрийн хөрөнгийн 20%-тай тэнцэх зээлийн хүсэлт шийдвэрлэх зохицуулалттай.

Санал: Өөрийн хөрөнгийн 5% эсхүл 8 тэрбум төгрөгийн аль багаар тооцож олгох эрхийг олгохоор шийдвэрлэв.


- 2) Гэрээ байгуулах эрх олгох тухай NES системд орохтой холбоотой тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийхтэй холбоотойгоор дараах асуудлыг хэлэлцэв.
  - Саммит ХХК-тай 716,340,900 төгрөгийн үнийн саналд зөвшөөрөл олгов.
  - Сард 6,160,000 төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Виртуал ворад" ХХК-тай NES систем нэвтрэх хүртэлх хугацаанд түрээслэхийг зөвшөөрөв.
- 3) NES систем нэвтрүүлэх гэрээ байгуулах эрх олгохтой холбоотойгоор "Грийп сити" ХХК-тай 625,240,000 төгрөгийн гэрээ байгуулах эрх олгон шийдвэрлэв.
- 4) Иргэдийн апп-ын нээлттэй API холболт хийх хөгжүүлэлттэй холбоотой 50 сая орчим төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэхтэй холбоотойгоор апп-ын өнгө төрхийг өөрчлөх, иргэд болон байгууллагуудад зориулсан онлайн банк үйлчилгээний хөгжүүлэлттэй холбогдон гарах зардлыг 2023 оны банкны төсөвт тусгах санал гаргаж, хувьцаа эзэмшигчид дэмжин шийдвэрлэв.
- 5) Иргэн Д.Сэлэнгэд Ариг банкны 40 мянгат салбарын түрээсийн гэрээг үргэлжлүүлэн байгуулах, 3 жилийн хугацаатай 63 сая төгрөгөөр түрээслэх саналыг танилцуулан, хэрэв тухайн саналыг эс зөвшөөрвөл түрээсийн байрнаас нүүх арга хэмжээ авахаар шийдвэрлэв.
- 6) "Номин Холдинг" ХХК-тай "Нууц хадгалах гэрээ" байгуулах зөвшөөрөл олгох тухай асуудлаар хэлэлцэж зөвшөөрөл олгож ТУЗ-ийн хараат бус 2 гишүүн өгөхөөр шийдвэрлэв.
- 7) "Ариг банк" ХХК-ийн дүрмийн өөрчлөлтийг танилцуулахтай холбоотой асуудлаар хэлэлцэж, ХЭХ-аар танилцуулахаар шийдвэрлэв.
- 8) Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч томилох хүсэлтийг Монгол банкны Ерөнхийлөгчид явуулахаар шийдвэрлэв.

Түүнчлэн "Ариг банк" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо болон Аудитын хорооны хурал 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр дараах асуудлуудыг хянан хэлэлцэж, "Ариг банк" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Зээлийн эрсдэлийн танилцуулгатай холбоотойгоор Аудитын хорооны үйл ажиллагаа, хяналтын ажилтнуудын ажлын тайланг дүгнэж, чиглэл өгөн ажиллав.
2. Лог бүртгэлийн систем буюу программ худалдан авах шаардлагатай байгаа тухай хэлэлцэв.
3. Өгөгдөл оруулах журам баталж, дагаж мөрдүүлэхтэй холбоотой асуудлаар журмын төслийг боловсруулах, талавласан 12 ажлыг шийдвэрлэх, Гүйцэтгэх захиралд хугацаатай үүрэг өгсөн албан бичиг явуулах, мэдээлэл технологийн аудитор н.Энхтөрийн хяналтыг нэмэгдүүлэх, хөдлөнгийн аудитын дүгнэлтийг авч танилцах зэрэг асуудлуудыг тус тус хэлэлцэв.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

 Д.Түвшинтамир